



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 4/97

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Могод сум "Цагаан овоо"-г ойжуулах төсөл (151 га талбайг)"-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга:

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын

дарга)

Гишүүд:

Г.Бямбажаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн)

Г.Дэлгэр (Худалдан авах ажиллагааны газрын

мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл:

Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

А.Гэрэл (Худалдан авах ажиллагааны газрын

мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР